

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2024.01.25

Дархан-Уул аймаг

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоон үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулж, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл арга зүй

Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасны дагуу Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн “Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт”-ийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар, зорилтын хэрэгжилтийг энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр 4 ангилалд шилжүүлэн тооцлоо.

Гурав. Үнэлгээний дүгнэлт

“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр **6 бүлэг, 20 дэд бүлэг, 66 зорилтын хүрээнд 283 арга хэмжээг** хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **96.15%** буюу **4.8** онооны үнэлгээтэй байна.


“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 2023 онд хэрэгжүүлэхээр тусгасан **283** арга хэмжээнээс **262** арга хэмжээг **ХАНГАЛТТАЙ** гэж үнэлэв. Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

Үнэлгээний танилцуулга

Бодлого Үнэлгээ	Бүгд	Бодлого тус бүрээр																				
		1. Хүний хөгжил						2. Эдийн засгийн бодлого							3.Засаглалын бодлого			4. Ногоон хөгжлийн бодлого		5. Бус орон нутгийн хөгжлийн бодлого	6.Халдварт цар тахлаас үүдэлтэй ЭЗНХДТ бодлого	
		Эрүүл мэнд	Биеийн тамир	Боловсрол	Их дээд, мэргэжлийн сургууль	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	Соёл, урлаг	Санхүү, төсвийн зохицуулалт	Уул, уурхай хүнд үйлдвэрлэл	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Эрчим хүч	Зам, тээвэр ложистик	Барилга, хот байгууламж	Төрийн удирдлагын бодлого	Гамшгаас урдчилан сэргийлэх, батлан хамгаалах бодлого	Хууль, эрх зүйн бодлого	Ногоон хөгжил	Нүүрс төрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил	Бус орон нутгийн хөгжил	Халдварт цар тахлаас үүдэлтэй ЭЗНХДТБ	
Хяналтад авсан зорилтын тоо	66	5	3	4	1	11	1	4	1	3	2	1	2	4	5	2	3	4	4	3	3	
Хяналтад авсан арга хэмжээний тоо	283	30	8	19	5	37	5	11	4	26	9	6	13	27	21	6	11	16	11	11	7	
Үүнээс:	100 хувь	238	23	8	17	5	37	4	11	2	24	8	5	9	18	21	5	10	11	9	5	6
	90 хувь	24	5	1			1			1	1	1	2	5			5	1	1	1	1	
	70 хувь	14		1					1	1		1	1	4			1		1	4		
	50 хувь	3							1	1										1		
	30 хувь	4	2											1		1						
	0 хувь																					
Хэрэгжилтийн хувь	96.15 %	93.7	100	97.9	100	100	98.0	100	80.0	97.69	96.67	98.3	90.76	93.7	100	88.33	97.27	96.9	96.36	83.64	98.57	
Хэрэгжилтийн оноо	4.8 ОНОО	4.68	5.0	4.9	5.0	5.0	4.9	5.0	4.0	4.88	4.83	4.92	4.54	4.68	5.0	4.43	4.86	4.84	4.82	4.18	4.93	

Хэрэгжилтийг бодлого тус бүрээр харуулбал:

№	Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт
1	Хүний хөгжлийн бодлого	25	104	96.82% буюу 4.84 оноо
2	Эдийн засгийн бодлого	17	96	95.1% буюу 4.75 оноо
3	Засаглалын бодлого	10	38	97.36% буюу 4.86 оноо
4	Ногоон хөгжлийн бодлого	8	27	96.66% буюу 4.83 оноо
5	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	3	11	83.64% буюу 4.18 оноо
6	Халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, НХДТБ	3	7	98.57% буюу 4.93 оноо
Ерөнхий, дундаж үнэлгээ		66	283	96.15% буюу 4.8 оноо



Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, /шатлалаар/



№	Хэрэгжилтийн үнэлгээ, хувь	Арга хэмжээний тоо, эзлэх хувь
1	Үр дүнтэй буюу 100.0 %	238 (84.1%)
2	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 90.0%	24 (8.48%)
3	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	14 (4.95%)
4	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50.0%	3 (1.06%)
5	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30.0%	4 (1.41%)
Дүн		283 (100%)

Дөрөв. Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд

Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт болон тухайн жилд дэвшүүлсэн зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай буюу **50.0%**, **30%-иар** үнэлэгдсэн дараах арга хэмжээнүүд байна.

№	Үнэлгээ,%	Арга хэмжээ,тоо	Арга хэмжээний дугаар	Хариуцах нэгж
1	50%	3	118, 136, 272	ХБТХОХ
2	30%	4	9, 10, 167, 224	НБХ, ХБТХОХ, ТЗУХ

Тав. Дүгнэлт


“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2023 онд хэрэгжүүлэхээр тусгасан **283** арга хэмжээний хэрэгжилтийг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **96.15%** буюу **4.8** оноотой “**ХАНГАЛТТАЙ**” гэж үнэлэв.

2023 оны 11 дүгээр сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр ЗДҮАХ-ийн хэрэгжилтийн 288 арга хэмжээг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 93.4% буюу 4.67 онооны үнэлгээтэй байсан бол сайжруулалт хийж, зөвлөмж хүргүүлэн тухай бүр хяналт тавьж ажилласнаар 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 2.75% буюу 0.13 оноогоор өссөн үзүүлэлттэй байна.



“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтэд хийсэн хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний танилцуулгыг аймгийн ИТХ-ын нэгдсэн

хуралдаанд 11 дүгээр сарын 24-нд танилцуулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд нийт 288 арга хэмжээнээс зорилт, арга хэмжээний биелэлт, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүнтэй хэрэгжсэн 254 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 26 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 5 арга хэмжээ, үр дүнгүй 3 арга хэмжээ дүгнэгдсэн. Сайжруулалт хийж үйл ажиллагааны хэрэгжилтийг дахин тодруулга хийснээр үр дүнтэй хэрэгжсэн **262** арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн **14** арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай **7** арга хэмжээ байна. Тайлангийн хэрэгжилттэй холбоотой бодлого тус бүрээр үнэлгээ, хэрэгжилтийг дүгнэж цаашид анхаарах асуудал, хэрэгжүүлэх ажлыг тусган зөвлөмж боловсруулан ЗДТГ-ын даргын албан тоот, чиглэлээр бодлогын хэлтсүүдэд хүргүүлэн ажиллалаа.



Төрөл	Хэлтэс	Огноо	Ажлын тушаалтын нэр	Гарын үсэг	
Цахим хэлтэс	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	2023.11.20	ХШХ-ийн дарга П. Барсрайан	<i>[Signature]</i>	
	Төрийн ажирвалын үндэслэлийн хэлтэс	2023.11.20	ТЭҮХ-ийн дарга Д. Чалмадорж	<i>[Signature]</i>	
	Хууль, өрх зүйн хэлтэс	2023.11.20	ХЗХ-ийн дарга П. Алтансүмбэр	<i>[Signature]</i>	
	Хөгжлийн бодлого, төлөвлөгөө, зарчмын оруулалтын хэлтэс	2023.11.20	ХБТХХ-ийн дарга П.Батсух	<i>[Signature]</i>	
	Самуу, төрийн сангийн хэлтэс	2023.11.20	СТСХ-ийн дарга Б. Фигарасовичев	<i>[Signature]</i>	
	Нийслэлийн бодлогын хэлтэс	2023.11.20	НБХ-ийн дарга Н. Цаснор	<i>[Signature]</i>	
	Цэргийн шлөб	2023.11.20	ШШ-ийн дарга Д. Гэрэсүрэн	<i>[Signature]</i>	

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн №57 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлж буй “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “**Шинэ сэргэлтийн бодлого**”-ыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 02/08 дугаар тогтоолын хавсралтад “**долдугаар**” бүлгийг нэмсүгэй, гэсний дагуу **17** зорилт, **27** арга хэмжээг нэмж тусган төлөвлөгөөг гарган <http://new.unelgee.gov.mn/> цахим санд орууллаа.

“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” анх батлагдсан арга хэмжээгээр цахим санд орсон тул **6 бүлэг, 20 дэд бүлэг, 66 зорилтын 283 арга хэмжээ**-ний дагуу хэрэгжилтийг гарган хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Зургаа. Цаашид анхаарах асуудал: / ЗӨВЛӨМЖ /

“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2021-2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг үндэслэн дараах асуудалд анхааран, удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг **ЗӨВЛӨЖ** байна.

1. Агентлагаас аймгийн ЗДТГ-т ирүүлж буй бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнг журмын дагуу тухайн байгууллагын ХШҮ-ний багаар үнэлүүлэн, байгууллагын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулж байх.
2. Хүрэх, түвшин буюу зорилтот түвшинтэйгээ уялдуулж, “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-тэй тулгаж, ахиц өөрчлөлтийг тодорхой тусгах,
3. Аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсүүд харьяа агентлагаас ирүүлсэн хэрэгжилтэд хийсэн ажлын үр дүнг бүрэн гүйцэт тусгасан эсэх, найруулга үг үсгийн алдааг хянан, “Эрчимжүүлэх шаардлагатай, удаашралтай” арга хэмжээний шалтгаан нөхцөл, сайжруулах гарц шийдлийн саналыг тусгаж байх,
4. Шаардлагатай тохиолдолд нотлох фото зураг, материалыг PDF хэлбэрээр хавсаргаж ирүүлэх.
5. Төрийн захиргааны байгууллага бүр чиг үүргийн хүрээнд явуулж буй үйл ажиллагаа болон иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар үр дүнтэй тусгаж, үйл ажиллагааны хэрэгжилтээ бүрэн гүйцэт тайлагнаж, хэрэгжилтийг хангах.
6. Дархан-Уул аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 57 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хийгдэх үйл ажиллагааг хөтөлбөрт нэмж, тусгах.

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН

ЗАСАГ ДАРГА

Б. АЗЖАРГАЛ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

МЭРГЭЖИЛТЭН

Г.ГЭРЭЛМАА